



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/133

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Коронавируст халдвар /ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотоос тус аймаг руу нэвтрэх иргэдийн ПСР шинжилгээ болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, Хэрлэн сумын "М Ойл" постны үйл ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 21 хоногийн хугацаанд ажиллах 4 албан хаагчдын хоол, бичиг хэргийн зардал болон автомашины шатах тослох материалын зардлыг хавсралтаар тус тус баталсугай. .

2. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 3820960 /гурван сая найман зуун хорин мянга есөн зуун жар/ төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231010381

02
Аймгийн Засаг даргын 2021 оны
дугаар сарын 17 өдрийн Д/134
дугаар захирамжийн хавсралт

Байгууллагын нэр	ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ			
	Бичиг хэргийн зардал	Шатахуун, түлээний зардал	Хоолны зардал	Дүн
Цагдаагийн газар	1289960	851000	1680000	3820960
ДҮН	1289960	851000	1680000	3820960